



ХИЛИЙН ТОРОН СААД, ТҮҮНИЙ ХИЛ ХАМГААЛАЛТАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

BORDER FENCING AND THEIR CONSEQUENCES FOR BORDER SECURITY

Түвшинсайханы Баяр-Эрдэнэ*

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор, хошууч

Maj. Bayar-Erdene Tuvshinsaikhan, Professor, Department of Engineering and Technology, Border Service School, University of Internal Affairs

Базарбуриадын Сайханбаяр*

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, дэд хурандаа

Lt. Col. Saikhanbayar Bazarburiad, MA Scholar, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: saihnaa010300@gmail.com

Хураангуй: Хилийн инженерийн байгууламж болох торон саадыг хилийн шугамын явалтыг тодорхой болгох, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил зөрчигчийн хөдөлгөөнд саад учруулах, саатуулах, хилийн зөрчлийн шинж тэмдгийг хадгалах, холбоо, харилцан ажиллагааг зохион байгуулах, хилчдэд албан үүргээ гүйцэтгэхэд таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хил хамгаалалтад ашигладаг.

Монгол Улсын хилийн нийт урт 8252.6 км, үүнээс 3242.5 км нь байгалийн саадаар, үлдсэн 5010.1 км хэсэг нь хилийн инженерийн торон саадаар төхөөрөмжлөх боломжтой бөгөөд өнөөгийн байдлаар 50 гаруй хувь нь хилийн торон саадаар төхөөрөмжлөгдсөн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд хилийн инженерийн байгууламжийг нэмэгдүүлэх, чанар байдлыг дээшлүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч байна.

Улсын хилийн инженерийн торон саадыг сайжруулах, нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хилийн зөрчил 2.8, хил дамнасан малын хулгайн зөрчил 5, бэлчээрээр мал улсын хил давах зөрчил 2.3 дахин, иргэд хилийн зурвас, бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх зөрчил 19.4 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улсын хилийн хэсэгт ашиглагдаж байгаа хилийн торон саадын байгууламжийн чанар байдал, хил хамгаалалтад үзүүлэх нөлөөлөл, гадаад улсуудын туршлагыг мэдээлэл цуглуулах, асуудалд дүн шинжилгээ хийх аргыг ашиглан судалж, үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Abstract: Border engineering structure, such as fences, is utilized for border protection to define the border line, prevent violations of the border regime, hinder and detain violators, preserve evidence of border infractions, facilitate communication and interaction, and create favorable conditions for border guards to perform their duties.

The total length of Mongolian border is 8,252.6 km, of which 3,242.5 km are built with natural barriers, and the remaining 5,010.1 km can be equipped with border engineering fences; currently, more than 50% of this length is secured with border fences.

Recently Mongolian long-term development policy and the Government's Action Program have been implemented by taking step-by-step measures in order to increase and improve the quality of border engineering facilities.



Through the implementation of improvements to state border engineering barriers, border violations have been reduced by 2.8 times, cross-border livestock thefts by 5 times, livestock crossing the state border through pastures by 2.3 times, and unauthorized entry of citizens into border areas and zones by 19.4% percent.

The aim of this article is to study and evaluate the quality of border fences used in Mongolian border areas, their consequences for border security, and the experiences of foreign countries using data collection and problem analysis methods.

Түлхүүр үг: Инженерийн саад, Саадын байгууламж, Хилийн торон саад, Өргөст тор, Инженерийн байгууламж.

Keywords: Engineering barriers, Barrier structure, Mesh barriers, Barbed wire, Engineering structure.

Удиртгал

Улсын хилийн инженерийн байгууламжийг сайжруулах, нэмэгдүүлэх талаар сүүлийн жилүүдэд анхаарч 2021-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 аймгийн хилийн хэсэгт инженерийн торон саадыг шинэчлэх болон шинээр байгуулах ажлыг зохион байгуулсан.

Хилийн инженерийн торон саадыг сайжруулах, нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн үр дүнгээ өгч байгаа хэдий ч Улсын хилийн инженерийн байгууламжаар төхөөрөмжлөх боломжтой хилийн хэсгийн 50 хувь нь торон саадын байгууламжаар төхөөрөмжлөгдөөгүй байна.

Хил хамгаалалтад ашиглагдаж байгаа торон саадын байгууламжийн 40,7 хувь нь модон шонтой олон жилийн эдэлгээний явцад чанар байдал муудаж ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна.

Хилийн торон саадын байгууламжийн хил хамгаалалтад үзүүлэх нөлөөллийг хилийн цагийн байдлын мэдээ, хил хамгаалалтын үр дүнтэй харьцуулан шинжилгээ хийж, торон саадын байгууламжийн хэмжээ, загвар, хийцлэлийг тодорхойлох хэрэгцээ шаардлага байна.

Цаашид хилийн инженерийн саадын байгууламжийн чанарыг дээшлүүлж, шинэчлэх ажлыг эрчимтэй зохион байгуулан хил хамгаалалтын дохиолол хяналтын системтэй хослуулан

ашиглах шийдэл гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсын хилийн тухай хуульд **Улсын хил хамгаалалт** нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн (Хилийн тухай хууль, 2016) гэж заасан байдаг бөгөөд мөн тус хуулиар “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, **инженер-техникийн**, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг **улсын хил хамгаалалт** гэнэ” гэж тодорхойлжээ.

Монгол Улсын Хилийн тухай хуульд “**улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж**” гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон



ХИЛ СУДЛАЛ

бусад байгууламжийг хэлнэ гэж заасан байдаг.

Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ. (Хилийн тухай хууль, 2016) гэж Хилийн тухай хуульд заасан бөгөөд энэ зурваст инженерийн төрөл бүрийн саадуудыг байгуулдаг.

Хилийн инженерийн хангалтын арга хэмжээний үндсэн зорилго нь улсын хилийн шугамын явалтыг тэмдэглэх, хүч хэрэгслийг дэлгэн байрлуулах, хил зөрчигчийг цаг тухайд нь илрүүлэн саатуулах, хөдөлгөөнд саад учруулах, хилчид хилийн хэсэгт албан үүргээ амжилттай биелүүлэх, хил хамгаалалтыг хариуцсан хэсэгтээ үр дүнтэй зохион байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Инженерийн саад гэж- газар орон дээр түр болон байнгын байдлаар дэлгэн байрлуулсан буюу барьж байгуулсан инженерийн төхөөрөмжүүд, техник хэрэгслүүд, хүний оролцоотойгоор зориуд бий болгосон эвдрэл, нуранги, зэрэг зохиомол саадуудыг хэлнэ.

Инженерийн төрөл бүрийн саадууд нь улсын хил зөрчигч этгээдүүдийг энэ чиглэлд явуулахгүй, нэвтрүүлэхгүй байна гэсэн үг биш харин тодорхой хугацааны дотор түүний хөдөлгөөнийг хязгаарлах, эргэн тойрондоо хяналт-ажиглалт хийх, зарим үед тойрч өнгөрөхөөр явах, хилийн манааны хяналтад өртөхөөс айж бэргэх, цаг алдуулах зэргээр түүнийг цаг алдалгүй илрүүлж, саатуулах, мөрдөн хөөх, шаардлагатай үед буудлагын зэвсгийн галын хөнөөлд өртөх магадлалыг нэмэгдүүлж байдгаараа улсын хил хамгаалалтад зохих ёсоор эергээр нөлөөлдөг.

Цэрэг улс төрийн байдал хурцадсан, хилийн будилаан үүссэн, дайны үед дайсанд хохирол учруулах, илрүүлэх саатуулах, байлдааны ажиллагааны үед өөрт ашигтай нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор инженерийн саадуудыг ашигладаг.

Инженерийн саадыг гүйцэтгэх үүрэг хэв шинжээр нь тэсэрдэг болон тэсэрдэггүй, цахилгаанжуулсан, усны, хосолсон гэж ангилна.

Инженерийн саадын нягтралыг хариуцсан хэсгийн хилийн зөрчил, зэвсэгт мөргөлдөөн, үймээн самуун гарч болзошгүй чиглэлүүдэд төвлөрүүлнэ. Хилийн цэргийн ангийн хариуцсан хэсэгт тайван цагт тэсэрдэггүй өргөст утсан саад ашиглаж, цагийн байдал хурцадсан байлдааны ажиллагаа явуулж байгаа үед тэсэрдэг саадыг хил хамгаалалтад ашиглана.

Тусгаарлах (хамгаалалтын) хашаа, нам ба өндөр шонтой өргөст торон саад, дэлгэдэг өргөст тор (спираль тор), сараалжин хашаанууд, үл үзэгдэх торон саадууд багтана.

Зөөврийн хөдөлгөөнт саадад:

Чаггнууд, зараанууд, утсан ороомгууд, илэрц багатай (үл үзэгдэх) өргөст утсан торон саадууд орно. Тэдгээрийг суурин утсан саадыг хүчитгэх, саадуудын хамгаалалтын гүнийг нэмэгдүүлэх, гарцуудыг хаах, эвдэрч сүйдсэн хэсгийг халхлахад ашиглана. Үүнээс гадна хөрсний шинж чанар нь суурин хаалтыг байгуулахад хүндрэл учруулдаг эсвэл эсвэл түүнийг байгуулахад хугацаа хүрэлцэхгүй тохиолдолд хэрэглэнэ.

Өндөр шонтой өргөст торон саадыг 1,5-2,0 м өндөртэй 3-5 эгнээ шонгуудыг шатарчилсан дарааллаар байрлуулж шон хооронд өргөст торыг сүлжмэл хэлбэрээр байрлуулна. (хэвтээгээр – 5-10, ташуу диагональ – 2).

Нам шонтой утсан торыг хэд хэдэн эгнээ шонг шатрын дарааллаар, газраас 1,0-1,2 м өндөртэйгөөр хийж, хооронд нь

өргөст тороор сүлжин эгнээ тус бүрийн болон эгнээ хоорондын шонгуудыг орой дээгүүр нь 2 давхар утсаар сүлжиж нэгийг нь гогцоотой хийнэ.

Дэлгэмэл (задгай) өргөст торон саадыг бусад төрлийн саадыг барьж байгуулах цаг, хугацаа, нөхцөл боломжгүй үед хэрэглэдэг. Задгай өргөст утсыг намхан бут, өндөр өвстэй, намгархаг газар, мод огтлох газарт хожуулын дунд мөн тэрчлэн хад чулуутай газруудад хэрэглэхэд илүү тохиромжтой. Тавих үедээ утсыг нугалж, мушгиж тааралдсан хад, мод, бутыг орооно. Утсыг гадас, чагт, чулуугаар бэхэлж тавина.

Хүчитгэсэн утсан торон саад гэдэг нь ердийн утсан хашаа бөгөөд нэмэгдэл хажуугийн татлагатай түүн дээр 2-3 хэвтээ өргөст утсыг бэхэлсэн байна. Татлагыг хашааны 2 талд 1,5 м хэмжээтэй суулгасан жижиг шонд холбоно. Өргөст утсыг шонд ацтай хадаасаар бэхэлнэ. Хүчжүүлсэн утсан хашаан дээгүүр голцуу илэрц багатай (үл үзэгдэх) тороор бүрхэж өгнө. Торны доод үзүүрийг газарт 25 см урттай ацтай гадсаар, 2 м тутамд торны бүхий л хүрээнд суулгаж бэхэлнэ.

Дэлгэсэн үл үзэгдэх торыг 1 м тутамд алгасан дээгүүр нь зөрүүлж доод хэсгээр нь тогтоох цагариг эсвэл цулгай утсаар бэхэлж тогтооно.

Өргөст утсан зараа гэдэг нь нэг бүр нь 1,5 м урттай шовх үзүүртэй, өөр хооронд нь дундуур нь холбосон гурван гадсаар хийсэн каркасыг (хийц) хэлэх бөгөөд үзүүрүүдийг өргөст утсаар холбосон байна.

Өргөст утсан чагт гэдэг нь гурван чагтыг өөр хооронд нь голын дагуу холбож, өргөст утсаар сүлжиж ороосон каркасыг (хийц) хэлнэ.

Өргөст утсан ороомгийг газар оронд 2-3 эгнээ бүхий өргөнтэйгөөр, 1-2 давхар өндөртэйгөөр хийнэ. Ороомгийг тавихдаа өөр хооронд нь утсаар холбож гадсаар газарт бэхэлнэ. Газарт тавьсны дараа ороомог тус бүр нь 10 см урттай, 90

см өндөртэй цилиндр хэлбэртэй болдог (ороомог нь 50 ороодостой).

Утсан хаалтын үр ашигтай байдлыг хангахын тулд, тэдгээрийн өргөст тор ороомгийг нэмэгдүүлэх, үл үзэгдэх тороор бүрхэх, цахилгаанжуулах, суваг, шуудуу, нүхэн саадаар хүчитгэнэ.

Хамгаалалтын зааг хилд ойрхон байгаа чиглэлийг халхлахын тулд тэдгээрийн хооронд янз бүрийн туулахад хүндрэлтэй өргөст торон, үл үзэгдэгч торон саадуудаар халхалж өгнө. Тохиромжтой хаалтын төрөл ба эгнээний тоог тооцооллын ба туршилтын өгөгдөхүүнүүдийг үндэслэж тухайн хэсэг дэх нөхцөл байдал хил зөрчигч түүнийг давж гарах боломжит хугацаа газрын хэлбэр байдал, тэрчлэн хаалтыг барьж байгуулах хүч хэрэгслийг харгалзсан байна.

Цэрэг улс төрийн нөхцөл байдал эрс хурцадсан үед мөн дайны үед дайсны довтолж болзошгүй чиглэлд, танк болон бусад хуягт техник хэрэглэж болзошгүй тул тус чиглэлд танк эсэргүүцэгч, газар шорооны хаалт, шуудуу, налуу, эсрэг налуу, танкны урхи, саадууд, суулгацууд, төмөр (төмөр бетон) зараа, овоолго, өвлийн улиралд мөсөн цооногийг барьж байгуулна.

Цахилгаанжуулсан хаалт нь дайсны амьд хүчийг цахилгаан гүйдлээр хөнөөхөд зориулагдана. Үүнийг хил дээрх зэвсэгт халдлагыг таслан зогсоох, няцаах мөн дайны үед хэрэглэнэ.

Цахилгаанжуулсан хаалтын хамгийн их үр дүнтэй байдал гэнэтийн байх, бусад инженерийн саадуудтай хавсарсан байдлаар хэрэглэснээр хангагдана. Эдгээрийг голдуу дохиоллын хаалтаас арагш 30-40 м зайд, тэжээлийн шугамыг цахилгаанжуулсан хаалт хашаанаас ар тал руу 10-30 м зайд тус тус байршуулна.



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААЛЫН
МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААЛЫН



ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠴᠤᠳᠤᠯᠠᠯ

Тайван цагт санамсаргүйгээр хүн цахилгаан гүйдэлд цохиулахаас сэргийлж цахилгаанжуулсан хаалтыг өргөст торон саад эсвэл бусад төхөөрөмжөөр хязгаарлаж, анхааруулах

тэмдэг, пайз, самбарыг заавал байрлуулна.

Дэлхийн улс, орнуудын хил хамгаалалтад ашиглаж байгаа саадын байгууламжийн талаар:



Зураг-1. Испани-Мароккогийн хилийн хэсэг
Эх сурвалж: (Spanishbytes, 2020)

Инженерийн байгууламжийн тэр дотроо инженерийн биет саадын нэг онцгой хэлбэр нь хилийн шугамын дагууд байгуулсан хана, хэрмүүд юм. Дэлхий дээр өөрийн улсаа бусдаас хана, хэрмээр тусгаарлан аюулгүй байдлаа хангах гэсэн оролдлого их байдаг бол тэдгээр нь бараг л бүгдээрээ шахам хилийн бүсэд байрладаг байна Мароккогийн их хана буюу “аюулгүй

бүс” нэртэй энэ хана 2720 км үргэлжлэх ба Полисарийн партизануудын дайралтаас Марокког хамгаалах зориулалттай байгуулжээ. (spsrasd, 2024)

Хоёр Солонгосын хувьд бие биеэсээ хөдөлгөөн саатуулах асар том шуудуу, хана хэрмээр тусгаарлахыг илүүд үзсэн ба түүний ар талд хэзээ мөдгүй гал нээхэд бэлэн байдалтай их бууны батарей, пуужингийн харвах сууриуд байрлуулжээ.



Зураг-2. Өмнөд ба Хойд Солонгосын хилийн зааг
Эх сурвалж: (Shuster, 2010)

Энэтхэг-Пакистаны хооронд 3300 км үргэлжлэх их ханаар хил залгаа Пакистаны дайралтаас Кашмир мужаа хамгаалах зориулалттай.



Зураг-3. Энэтхэг-Пакистаны хилийн зааг
Эх сурвалж: (Press Trust of India, 2014)

Саудын Араб хөрш Йемен улстай хиллэх хэсэгтээ 7 км үргэлжлэх төмөр бетон хана байгуулж дээр нь нэмээд орчин үеийн цахим хяналтын төхөөрөмжүүдээр тоногложээ.

Саудын Араб нь Иракттай хиллэж байгаа хэсэгтээ 900 км үргэлжилсэн хана хэрэм босгожээ.



Зураг-4. Саудын араб-Иракийн хилийн зааг.
Эх сурвалж: (Agency, 2014)

Узбекстан улс Тажикстан улсаас, Арабын нэгдсэн Эмират улс Оманаас, Кувейт хөрш Иракаас хана, хэрмээр тусгаарлаж эхэлсэн байна. Турк улс Кипр улстай залгаа хэсэгтээ байгаа арлыг өөрийн бүрэлдэхүүн салшгүй хэсэг гэж үзээд мөн л хана босгож эхэлжээ.

Тайланд улс 2007 оноос Малайзтай залгаа хэсэгтээ мусульманы алан хядагчдаас хамгаалах нэрээр 75 км үргэлжлэх хана байгуулан Тайландын цэргээр тогтмол эргүүл хийж байна. Пакистан улсын хувьд Афганистантай хиллэж байгаа хэсэгтээ 2400 км



МОНГОЛЫН ИРГЭД
ДЭМЖСЭН
ХҮҮЛЬ



ХҮҮЛЬ САХИУЛАХҮЙ

үргэлжлэх өргөст утсан хашаа байгуулж зарим хэсгийг хэдийнээ цахилгаанжуулжээ.

АНУ-ын хувьд Мексиктэй хиллэж байгаа хэсэгтээ хана хэрмийг байгуулан хар тамхи, мансууруулах бодис нууцаар хил давуулах, дамлах, дүрвэгсдийн хууль бус урсгалыг таслах зорилго тавьж байгаа ч үр дүн төдийлөн хүрэхгүй байна. (Жаргал, 2023)

Европын хувьд Испани улс (Ceuta ба Melilla) Мароккотой залгах хэсэгтээ өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах хана босгож сахрын наймаачдын дайралтаас хамгаалгахаар оролдож байгаа бол, Хойд Ирландын католик болон протестант шашинтнуудын оршин суугчдыг 30 жилийн туршид энэхүү ханаар хоёр тосгон болгон тусгаарлаж байна

Хамгийн сүүлийн баримтаар Украин улс ОХУ-тай хил залгаж байгаа хэсэгтээ хана хэрэм, суваг шуудуу, хянах байгууламжууд бүхий цоо шинэ цогцолборыг байгуулж эхлээд байна.

Улсын хилийн хэсэгт инженерийн зарим төрлийн иймэрхүү биет саадуудыг байгуулах, нэгэнт байгаа саадыг улам боловсронгуй болгон ашиглах шаардлага өнөө хэр хэвээрээ төдийгүй зарим талаараа улам бүр ач холбогдолтой болсоор байна.

Ялангуяа дүрвэгсдийн асуудал, амьдрах нөхцөлөө сайжруулах, өндөр цалинтай ажил эрхлэх зорилгоор бөөнөөрөө, нууцаар хил давах гэсэн оролдлого дэлхийн зарим улс орнуудад (АНУ, Бельги, Унгар, Грек, Португал, Хойд Солонгос, БНХАУ-д) гарсаар байна.



Зураг-5. Европыг дүрвэгчдээс хамгаалах гэсэн оролдлого

Эх сурвалж: (Риа новости, 2015)

Нууц далдуур дүрвэгчдийн дийлэнх хувь нь хуурай гарын хилээр дамжин өнгөрөхийг оролддог бөгөөд харин далай, тэнгисээр дамжих нь тэдгээрийн амь насанд нэн аюултай байдаг хэдий ч тийм оролдлого багагүй арсаар байгаа юм.

Хөгжлөөр бага буурай зарим орнууд улсын хилээ бат цоожтой байлгахад анхаарахаасаа илүүтэйгээр хил залгаа баян орнуудын хүч хэрэгсэлд найдах болсон байдал ч харагдаж байна. Жишээлбэл АНУ нь Канад (8900 км),

Мексик (3200 км) улсуудтай хуурай газраар хиллэх бөгөөд энэ хэсгийн хил хамгаалалт нь өөрийн гэсэн онцлогтой байдаг.

Канадын хуурай газрын болоод усан хилийг 10 мянга гаруй хүнтэй эзэн хааны морьт цагдаа болон тэнгисийн хилийн албаны хүчээр хамгаалдаг.

АНУ-ын хуурай газрын хилийн Үндэсний аюулгүй байдлын яамны бүрэлдэхүүнд багтдаг хилийн хамгаалалт, гаалийн хяналтын агентлаг эрхлэн гүйцэтгэнэ. Энэ агентлагийн

бүрэлдэхүүн нь ойролцоогоор 60 мянган гаруй хүн байх ба түүнээс 17 мянга нь улсын хил хамгаалалтыг гардан гүйцэтгэдэг цэрэгжсэн албан хаагчид байдаг бол агентлагийн жилийн төсөв нь 12,1 их наяд доллар болж байна.

Монгол Улсын хил хамгаалалтын саадын байгууламжийн өнөөгийн байдал



Монгол Улсын хилийн **8252.658** км хэсгийн **30.6** хувь нь инженерийн

байгууламжаар төхөөрөмжлөгдсөн.

Хилийн хэсэгт 2016-2023 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалт (УТХО) болон урсгал зардлаар хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлүүдэд торон саад шинээр байгуулсан нь хилийн зөрчлийн тоо өмнөх 10 жил (2000-2010)-тэй харьцуулахад **71.7** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын хилийн **8252.6** км хэсгийн **1075.8** км буюу (**13.0%**) нь байгалийн саадтай, **901.1** км буюу (**10.9%**) нь усан хилтэй, **30.6%** инженерийн байгууламжтай, **45.4%** нь инженерийн байгууламжаар төхөөрөмжлөгдөөгүй тул улсын хилийн зарим хэсгээр хил давуулан мал хулгайлах, хууль бус наймаа хийх, цагаач иргэд бөөнөөр хил даван орж ирэх, хил дамнасан гэмт хэрэг үйлдэгдэх, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил гарч болзошгүй байна.

Эрх зүйн үндэслэл:

Хил хамгаалалтын инженерийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл нь эрх зүйн баримт бичгүүдэд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.2.3 дах заалтад “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ”

-“Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын 1.8 дахь заалтад “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх” мөн баримт бичгийн 2.3 дахь заалтад “...улсын хилийн бүс, зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, дохиолол, зам тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх”

-Монгол Улсын Хилийн тухай хуулийн 32.1.1 дэх заалт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах”, 36.1.2 дахь заалт “Улсын хил хамгаалалтын эрх ашгийн үүднээс хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт хүч хэрэгслээ байрлуулах, инженер, техникийн болон зам харилцааны байгууламж барьж байгуулах”, Хилийн тухай хуулийн 21.3 дахь заалт “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хил орчмын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймэр гарахаас урьдчилан сэргийлж, гарсан гал түймрийг унтраах арга хэмжээ авна”; (Хилийн тухай хууль, 2016)

-“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.1 дэх заалтад “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана”

-Монгол Улсын Хууль Зүйн Сайдын 2016 оны а/120 дугаар тушаал “Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн 4.2.5.Хилийн инженерийн төхөөрөмжлөл (торон саад, мөр хянах зурвас, ойн зурвас)-ийг шинээр байгуулах, сэргээх, тусгай



МОНГОЛ УЛСЫН
ХИЛ ХАМГААЛАЛТЫН
ИНЖЕНЕРИЙН
БАЙГУУЛАМЖ



ᠬᠡᠭᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

зориулалтын техник хэрэгслүүдийг шинэчлэх;

-Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1 “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшилгйг ашиглана”;

Улсын хил хамгаалалтад ашиглагдаж байгаа инженерийн байгууламж торон саадыг нэмэгдүүлснээр дараах үр дүнг хил хамгаалалтад үзүүлнэ. Үүнд:

Хилийн инженерийн байгууламжийн нягтрал нэмэгдсэнээр хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох боломж нэмэгдэнэ.

Хилийн шугамын явалт тодорхой болж, инженер технологийн бусад системийг хослуулан ашиглах боломжтой болно.

Хилийн зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж, улсын хил хамгаалах байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг болон МУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж улсын хил хамгаалалтын халдашгүй дархан байдал цаашлаад үндэсний аюулгүй байдал хангагдах үндэслэл болно.

Дүгнэлт

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд улс, төр эдийн засгийн нөхцөл байдлын улмаас үүсээд байгаа дүрвэгсдийн асуудал, хил дамнасан гэмт бүлэглэл, хар тамхи, хүний наймаа зэрэг асуудлууд нь улс орнууд хилийн аюулгүй байдалд аюул учруулж, төрөл бүрийн инженерийн байгууламж байгуулах,

дохиолол хяналтын системээр төхөөрөмжлөхөд хүргэж байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна.

АНУ, БНХАУ, Энэтхэг, БНСУ, БНАСУ, ОХУ, Израйл зэрэг орнууд хилийнхээ хэсгийг өндөр хана хэрэм байгуулах, өргөст торон саадыг орчин үеийн дэвшилтэт техник технологитой хослуулан төхөөрөмжилж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлсээр байна.

Монгол Улсын хувьд урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хилийн хэсгийг инженер, дохиолол, хяналтын байгууламжаар төхөөрөмжлөх талаар холбогдох заалтуудад тусгагдаж, улсын хил хамгаалалтыг инженер-техникийн арга хэмжээгээр зохион байгуулах ажил үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид хилийн инженерийн байгууламжаар төхөөрөмжлөх боломжтой хэсгийг 100 хувь торон саадын байгууламжаар халхалснаар хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох боломж нэмэгдэж, Хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг болон МУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж улсын хил хамгаалалтын халдашгүй дархан байдал цаашлаад үндэсний аюулгүй байдал хангагдах үндэслэл болно гэж үзэж байна.

Ашигласан материал

Agency, T. N. (2014 оны 09 04).

tasnimnews.com. Tasnim News

Agency:

<https://www.tasnimnews.com/en/news/2014/09/07/490406/saudi-unveils-900km-fence-on-iraq-border-ээс> Гаргасан

Press Trust of India. (2014 оны 09 20).

indianexpress.com. The Indian express journalism of courage: <https://indianexpress.com/article/india/india-others/200-armed->

- militants-waiting-across-loc-to-infiltrate-but-security-grid-in-place-to-neutralise-them-army/-ээс Гаргасан
- Shuster, M. (2010 оны 07 06). <https://www.npr.org/>. National Public Radio: <https://www.npr.org/2010/07/06/128337461/nixon-considered-nuclear-option-against-n-korea-ээс> Гаргасан
- Spanishbytes. (2020 оны 02 01). spanishbytes.com/vallas. SpanishBytes: <https://www.spanishbytes.com/vallas/-ээс> Гаргасан
- spsrasd. (2024 оны 01 14). spsrasd.info. Sahara press service: <https://spsrasd.info/ru/2024/01/14/1942.html-ээс> Гаргасан
- Жаргал, Д. (2023 оны 10 06). *АНУ-Мексикийн хилийн дагуу хана барих ажлыг үргэлжлүүлнэ*. Монцамэ: <https://www.montsame.mn/mn/read/328386-ээс> Гаргасан
- Новости, Р. (2015). *РТ на русском*. <https://russian.rt.com/article/117572-ээс> Гаргасан
- Риа новости. (2015 оны 09 17). <https://russian.rt.com/>. Семья-Россия: <https://russian.rt.com/article/117572-ээс> Гаргасан
- Хилийн тухай хууль (Улсын их хурал 2016). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418-ээс> Гаргасан



Дотоод Ажлын Яаман
 Министрийн Тамгын Газар